



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

08

2013 оны 07 сарын 31 өдөр

Дугаар 273

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2; 8.3, Эрүүл мэндийн яамны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, зарим хяналтыг сайжруулах зорилгоор ТУШААХ нь:

1. "Эрүүл мэндийн яамны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөлийн санхүүжилтийн журам"- ыг хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг 2013 оны 08 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлж, үйл ажиллагааг нь зохицуулж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д. Мөнхбат/, Санхүү эдийн засгийн хэлтэс /Д.Дамдиндорж/- т тус, тус үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /А.Эрдэнэтуяа /- д даалгасугай.

САЙД



Н.УДВАЛ

002272

Эрүүл мэндийн сайдын 2013 оны  
07 дүгээр сарын 31 ний өдрийн 273 дугаар  
тушаалын хавсралт


## ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЖУРАМ

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Энэхүү журам нь Эрүүл мэндийн яамны мэргэжлийн салбар зөвлөлийн санхүүгийн үйл ажиллагааг зохицуулахад мөрдөгдөнө.
2. Мэргэжлийн салбар зөвлөл нь санхүүгийн аливаа харилцаанд оролцохдоо Монгол улсын "Төсвийн тухай", "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хууль, энэхүү журам болон холбогдох бусад хууль эрхийн актыг үндэслэл болгоно.
3. Мэргэжлийн салбар зөвлөлийн тухайн жилийн үйл ажиллагаанаас олсон орлого, төсвийн үлдэгдэл нь дараагийн салбар зөвлөлийн үйл ажиллагаанд үргэлжлэн зарцуулагдана.

### ХОЁР. МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОМЖИТ ОРЛОГО.

- 2.1 Ерөнхий мэргэжилтэн нь /мэргэжлийн салбар зөвлөл нь/ дараах үйл ажиллагаанаас орох орлогыг Эрүүл мэндийн яаман дахь мэргэжлийн салбар зөвлөлийн дансанд төвлөрүүлж, эргэн зарцуулна.
- 2.2 Мэргэжлийн салбар зөвлөлийн орлого нь дараах эх үүсвэртэй байж болно. Үүнд:
  - 2.2.1 Мэргэжлийн зөвлөлүүдийн үйл ажиллагаанд зориулан эрүүл мэндийг дэмжих сангаас хөтөлбөр хэрэгжүүлэхээр авсан санхүүжилт,
  - 2.2.2 Эмч, эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн зэрэг олгох шалгалтад бэлтгэх сургалт зохион байгуулах,
  - 2.2.3 Зэргийн шалгалтын ном сурах бичиг, гарын авлагыг мэргэжлийн зөвлөлийн нэрээр боловсруулж гаргах, борлуулах,




- 2.2.4 Эмч, эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн зэрэг олгох шалгалтыг зохион байгуулахад мэргэжлийн дэмжлэг үзүүлсэн бусад арга хэмжээнүүд,
- 2.2.5 Тухайн мэргэжлийн чиглэлээр сургалт явуулах, ном сурах бичиг боловсруулж, үнэлж, зарах,
- 2.2.6 Гадаад, дотоодын бусад мэргэжлийн нийгэмлэг, холбоод, олон улсын байгууллага, ТББ-тай хамтарсан сургалт, семинар зохион байгуулахад олсон орлого,

**ГУРАВ. ОРЛОГЫН ЗАРЦУУЛАЛТ .**

- 3.1 Мэргэжлийн салбар зөвлөлийн дотоод хурал, бичиг, баримт боловсруулах, харилцах, бичиг хэргийн үйл ажиллагаанд зориулсан тогтмол зардал,
- 3.2 Гишүүдийн хуралд ирж, буцах томилолтын зардал (ЭМЯ-ны холбогдох газар хэлтэстэй зөвшилцөн зөвшөөрөгдсөн тохиолдолд)
- 3.3 Эрүүл мэндийн яамны холбогдох газар, хэлтсийн захиалгаар эсвэл зөвшилцөн зохион байгуулах мэргэжлийн хурал, зөвлөгөөн түүнд шаардагдах зардал,
- 3.4 ЭМЯ-ны захиалгаар, эсвэл зөвшилцөн удирдамж, гарын авлага боловсруулсан ажлын хөлс олгох,
- 3.5 ЭМЯ-ны захиалгаар, эсвэл зөвшилцөн дотоод, гадаадад зохион байгуулсан хурал, зөвлөгөөнд зөвлөлийн төлөөллийг оролцуулахад шаардагдах зардал (хангалттай санхүүгийн нөөцтэй тохиолдолд),
- 3.6 ЭМЯ-ны захиалгаар хөдөө, орон нутагт очиж ажиллах, мэргэжлийн дүгнэлт өгөх, хурал, сургалт зохион байгуулахад шаардагдах томилолтын зардал,

**ДӨРӨВ. МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТИЙГ ХЯНАХ ДАНС.**

- 4.1 Мэргэжлийн салбар зөвлөлийн санхүүгийн үйл ажиллагааг хянах нэгдсэн дансаар дамжуулан үйл ажиллагааг явуулна.
- 4.2 Энэхүү нэгдсэн дансыг холбогдох журманд нийцүүлэн, захиран зарцуулах эрхийн зохицуулалтын асуудлыг ЭМЯ-ны санхүүгийн эрх бүхий ажилтан хяналт тавьж, шийдвэрлэнэ.

- 
- 4.3 Дансны гүйлгээг эрүүл мэндийн салбарт олон улсын байгууллага болон сангуудын үйл ажиллагааны журмын дагуу, төсөв, удирдамж батлуулан холбогдох эрх бүхий албан тушаалтнуудаар хянуулж, батлуулан, үйл ажиллагаандаа зарцуулна.
- 4.4 Төсвийн зардлыг тооцохдоо Эрүүл мэндийн сайдын 2013 оны 162 тоот тушаалын 2 дугаар хавсралтыг баримтална.
- 4.5 Санхүүгийн зарцуулалтын тайланг ЭМЯ-ны Санхүү эдийн засгийн хэлтэс, салбарын ерөнхий нягтлангаар хянуулж, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг архивт шилжүүлнэ.
- 4.6 Ерөнхий мэргэжилтэн нь Мэргэжлийн салбар зөвлөлийн тухайн жилд хийх ажлын төлөвлөгөө, тайланд дээрхи үйл ажиллагааг тусгана.

#### **ТАВ. ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ**

- 5.1 Ерөнхий мэргэжилтэн нь санхүүгийн үйл ажиллагааны тайланг улирал бүрийн 4 дэх долоо хоногт багтаан ЭМЯ-ны холбогдох газар, хэлтэст тайлагнана.
- 5.2 Эрүүл мэндийн яамны ерөнхий мэргэжилтэн нь тамга, хэвлэмэл хуудсын үлдэгдэл, эрхийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын тайлан, үйл ажиллагааг явуулсан талаархи архивын нэгж болон /харилцсан бичиг, боловсруулсан бичиг баримтуудын эх хувь/-ыг дараагийн ерөнхий мэргэжилтэн, мэргэжлийн салбар зөвлөлд Эрүүл мэндийн сайдын тушаал гарсанаас хойш ажлын 10 хоногт багтаан ЭМЯ-ны холбогдох газар хэлтсийн дарга, мэргэжилтнүүдийг байлцуулан хүлээлгэж өгнө.
- 5.3 ЭМЯ-ны холбогдох газар хэлтсүүд мэргэжлийн салбар зөвлөлийн тухайн жилд явуулсан санхүүгийн үйл ажиллагаа, түүний тайланг улирал бүр үнэлж, дүгнэлт, зөвлөмж гаргаж үйл ажиллагааг сайжруулж ажиллана.

ooOoo